



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар A/136

Улаанбаатар хот

Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх
журам болон Галын аюулгүй байдлын дотоод
дүрэм шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, MNS 5566:2020 Аж ахуйн нэгж, байгууллагын гал унтраах анхан шатны хэрэгслийн зайлшгүй шаардлага, норм, "Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм"-ийн 6 дугаар зүйлийн 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус үйлдвэрийн газрын "Галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Галын аюулгүй байдлын дотоод дүрэм"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Батлагдсан журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардагдах хөрөнгийн холбогдох эх үүсвэрээс тухай бүр шуурхай санхүүжүүлж ажиллахыг Ерөнхий нягтлан бодогч (Э.Ганбаатар), Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн Тооцооны нягтлан бодогч (Б.Батсүх) нарт зөвшөөрсүгэй.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шуурхай штаб болон Төлбөр авах үйл ажиллагааны хэлтэс (Б.Энхбаатар)-д тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.
5. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан тус үйлдвэрийн газрын захирлын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/22 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Д.ОЮУНБОЛД

10250058

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын
2024 оны 18 дугаар сарын 31-ний өдрийн
1/156 тоот тушаалын хавсралт 1...



ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилт нь галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтнуудын эрх үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү журам нь үйлдвэрийн газрын удирдлага, бүх хэлтэс, нэгж, төлбөр авах цэгүүдэд хамааралтай болно.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

"гал түймэр" гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулахыг;
"гал түймэр унтраах" гэж гал түймрийн үед хүний амь насыг аврах, гал түймрийг унтраахын тулд тодорхой хүн хүч, техник хэрэгслээр тохирсон арга, хэлбэрийг ашиглан гүйцэтгэх үйл ажиллагааг;

"гал түймэр унтраах удирдагч" гэж гал түймэр унтраах үйл ажиллагааг газар дээр нь удирдан зохион байгуулах гал түймэртэй тэмцэх мэргэжлийн алба хаагчийг;

"галын аюулгүй байдал" гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;

"гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж" гэж барилга байгууламж дахь гал түймрийг илрүүлэх, мэдээлэх, унтраах автомат тоног төхөөрөмж, утаа зайлуулах систем, гал унтраах усан хангамж, хүн нэг бүрийн болон нийтийн тусгай аврах хэрэгслийг;

"галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг" гэж галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам, заавар, норм, стандартыг;

"гал түймрийн аюултай нөхцөл байдал" гэж гал түймэр гарсан тохиолдолд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд шууд аюул учруулах нөхцөл бүрдсэнийг;

"гал түймэр гарсан тухай акт" гэж гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учирсан болохыг нотолсон баримт бичгийг;

"гал түймэр гарсан тухай тэмдэглэл" гэж гал түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учраагүй болохыг тодорхойлсон баримт бичгийг;

"гал түймрийн аюулын үнэлгээ" гэж барилга байгууламжийн ангилал, зураг төсөл, хийц, бүтээц, үйлдвэрлэлийн технологи, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн зориулалт, ашиглалт нь норм, нормативын шаардлагад нийцэж байгаа эсэх, гал түймрээс учирч болзошгүй хохирлын хэмжээг тодорхойлж үнэлэхийг;

"гал түймрээс хамгаалах үйлчилгээ" гэж гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, гал түймрээс хамгаалах нэмэлт арга хэмжээ авах, гал түймэртэй тэмцэх хэсэг, гал түймэртэй тэмцэх гэрээт анги, хяналтын нэгж ажиллуулахыг;

"галын аюултай бүтээгдэхүүн" гэж галын эх үүсвэрээс болон химийн урвалын үйлчлэлээр хялбар авалцан асах, хорт хий, утаа ялгаруулах, тэсэрч дэлбэрэх аюултай бодис, материалыг;

"томилгоот бүрэлдэхүүн" гэж гал түймэр унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэлтэйгээр 24 цагаар үүрэг гүйцэтгэх гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч, тасгийн захирагч, галын автомашины жолооч, гал сөнөөгч, дуудлага хүлээн авагч зэрэг мэргэжлийн алба хаагчдыг;

"объектын гал түймэр" гэж бүх төрлийн өмчийн хэлбэрийн барилга байгууламж, эд хөрөнгө, тоног төхөөрөмжид гарсан гал түймрийг;

"ой, хээрийн гал түймэр" гэж ой болон хээрийн бүсэд шатамхай ургамлаар дамжин гал хяналтгүй тархахыг хэлнэ.

Гурав. Галын аюулгүй байдлыг хангах талаар ажил олгогчийн эрх

1. Галын аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс арга зүйн туслалцаа зааварчилгаа, зөвлөгөө авах. (Онцгой байдлын газар, МУЗН гэх мэт)

2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

3. Гал түймрийн аюулын үнэлгээг бүх ажлын байр, тасаг, нэгж, барилга байгууламж, тоног төхөөрөмжүүдэд хийлгэх.

4. Барилга, байгууламжийн объект тус бүр нь галын аюулгүй байдал, галын аюулаас хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх дүгнэлт гаргуулах.

Дөрөв. Галын аюулгүй байдлыг хангах талаар ажил олгогч нь дараах үүрэгтэй.

1. Холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг биелүүлэх, галын аюулгүй байдлыг хариуцсан албан тушаалтныг томилох.

2. Байгууллагын галын аюулгүй байдлыг хариуцан хангах, шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах.

3. Галын аюулгүй байдлын журмыг баталж, гал түймэр унтраах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтийг хангуулах.

4. Барилга байгууламж, үйл ажиллагаанд хэрэглэгдэх бодис, материалын гал түймрийн аюулын зэрэглэлийг баталгаажуулах.

5. Байгууллагын галын дүгнэлтийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах.

Тав. Галын аюулгүй байдлыг хангах талаар хэлтсийн дарга нар дараах үүргийг хүлээнэ.

1. Үйлдвэрийн газрын барилга, байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримтлах.

2. Лаборатори, ТАТТ багийн тоног төхөөрөмжийн ажиллагаа, ашиглалт, техникийн үйлчилгээний явцад галын аюулгүй ажиллагааны дүрэм, журам, заавар, технологийн карт хэрхэн мөрдөгдөж байгаад хяналт тавих.

3. Үйлдвэрийн газрын нийт ажилтан албан хаагч нарыг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4. Гал түймэр унтраах үйл ажиллагаанд шуурхай дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

5. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис, материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангах.

6. Гал түймрийн улмаас газарт учирсан хохирлын хэмжээг эрх бүхий үнэлгээний байгууллагаар тогтоолгох.

7. Гал түймрийн үед ажлын байрнаас дүрвэн гарах нөөц хаалганы байршил, гал унтраах хэрэгсэл, хяналтын камер, дохиоллын систем, автомат гал унтраах систем багаж, хэрэгслийг ажиллуулах талаар ажилтнуудад зааж сургах сургуулилтыг тогтмол хийсэн байна.

Зургаа. Галын аюулгүй байдлыг хангах талаар хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн дараах үүргийг хүлээнэ.

1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээг хэрэгжүүлэх.

2. Үйлдвэрийн газрын байгууламж, тоног төхөөрөмжүүдийн галын аюулгүй байдлын норм, нормативын шаардлагыг хангах гал унтраах хэрэгсэл, дохио санамж, материал, хэрэгслийн хэрэгцээг жил бүр үнэн зөв тооцож гаргуулан авч нэгтгэн албаны нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулах.

3. Галын аюулгүй байдлын жилийн ажлын төлөвлөгөө батлуулж мөрдөж ажиллах.

4. Барилга, байгууламж объект тус бүрийн галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах автомат тоног төхөөрөмж, галын анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраах хэрэгсэл, дохио санамж, материал галын аюулгүй байдлын норм нормативын шаардлагыг хангаж байгааг шалгах хуудсаар хяналт хийх (Хавсралт 1)

5. Гал унтраах хэрэгслийг сар бүр сэгсэрч хөдөлгөн баталгаажуулах

6. Галын аюултай бүтээгдэхүүн, гал түймрээс хамгаалах (хяналтын камер, дохиоллын систем, автомат гал унтраах систем) тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдалд хяналт тавин хариуцсан хэлтэстэй нягт хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаа эрхэлсэн дэд захиралд бичгээр мэдэгдэнэ.

Долоо. Галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтны эрх үүрэг

Галын аюулгүй байдлыг хангах талаар нийт ажилтны эрх

1. Гал түймэр гарсан үед амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалуулах, гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтооход биечлэн оролцох

2. Гал түймэртэй холбогдолтой үнэн зөв мэдээ авах

3. Галын аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг холбогдох байгууллагаас шаардах

4. Галын түймэртэй тэмцэх сайн дурын хэсэгт ажиллах

Галын аюулгүй байдлыг хангах талаар ажилтны үүрэг

1. Галын аюулгүй байлын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх

2. Тасгийн ажлын байранд гал түймэр гарч байгаа тохиолдолд Улаанбаатар хот Баянгол дүүргийн онцгой байдлын газарт дуудлага өгөх.

3. Галын аюулгүй байдлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг сахин биелүүлэх.

4. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, унтраах үйл ажиллагаанд бололцоотой дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

5. Гал түймэр гарч болзошгүй зөрчил, дутагдлыг холбогдох байгууллагад шуурхай мэдээлэх.

Найм. Галын аюулгүй байдлын талаар тавигдах шаардлага

Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар байгууллагын хэмжээнд дараах зүйлүүдийг зайлшгүй хийсэн байх шаардлагатай. Үүнд:

1. Барилга байгууламжуудын хийц бүтээцийн шийдэл нь гал түймэр гарсан тохиолдолд ажилтнуудын аюулгүй байдлыг хангахуйц, гал түймрийг бага хохиролтойгоор унтраах бололцоог хангасан байна.

2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байна.

3. Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг болосвруулан эрх бүхий этгээдээр баталгаажуулж, ажилтнуудад сургалт хийсэн байна.

4. Барилга байгууламжуудыг гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангасан байна. Анхан шатны багаж хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

5. Гал түймэр гарсан үед барилга байгууламжаас дүрвэн гарах схемийг урьдчилан боловсруулж нийтэд харагдахуйц газарт байрлуулсан байх ба шаардлагатай байгууламжууд дээр аваарын гэрлэн зохиолол, дүрвэн гарах чиглэлийг заах тэмдэг тэмдэглэгээг байршуулсан байна.

6. Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, ажилтнуудыг сургаж дадлагацуулсан байна.

7. Ажлын байруудад гал унтраахад зориулсан зориулалтын гал унтраах хэрэгсэл, багаж хэрэгслийг байрлуулсан байна.

8. Галын аюулаас урьдчилан сэргийлж барилга байгууламж, өрөө тасалгаа бүрт цахилгаан хэрэгслийг хэрхэн ашиглах талаарх зөвлөмжийг байрлуулсан байна.

9. Албаны өрөө тасалгааны нөөц түлхүүрийг тусгай хайрцагт хийж лацдан жижүүр-манаачид хадгалуулж яаралтай тохиолдолд гаргаж хэрэглэнэ.

10. Ажилтнууд болон үйлчлүүлэгч нар тамхи татах цэгээс бусад газарт тамхи татахгүй байх, татсан тамхиныхаа галыг бүрэн унтрааж зориулалтын саванд хаядаг байна.

11. Ажлын цаг дуусмагц албан болон ахуйн хэрэглээний цахилгаан хэрэгслүүдийг эх үүсвэрээс нь салгаж гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

Ес. Хүлээх үүрэг хариуцлага

1. Ажил олгогч нь энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллана.


2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Байгууллагын дотоод журам болон Галын аюулгүй байдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

3. Галын аюулгүй байдлыг хангахтай холбоотой хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам, норм стандарт зөрчсөн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Хяналтын хуудас

№	Үзүүлэлт	Чанар байдлын үзүүлэлт	
1	Барилга байгууламжийн нэр		
2	Ажлын байр		
3	Шалгалт хийсэн огноо		
4	Үзүүлэлт	Иж бүрдэл	Гал унтраах хэрэгслийн төрөл загвар
5	Гал унтраах хэрэгсэл	Чанар байдлын тэмдэглэл	
		Даралтын заалт	
		Шланг хошуу хэвийн эсэх	
		2 удаа сэгсэрсэн эсэх	
		Баталгаат хугацаа хүчинтэй эсэх	
		Лац тэмдэг бүтэн эсэх	
6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж	Дуут дохиолол	
		Гэрлэн дохиолол	
		Утаа мэдрэгч	
		Халуун мэдрэгч	
		Удирдлага	
7	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	Хүрз	
		Галын дэгээ	
		Хувин	
		Сүх	
		Элстэй сав	
		Хөрөө	
		Царил	
		Жоотуу	
		Эсгий болон галд тэсвэртэй бүтээлэг	
		Галын гидрат, хошуу	
8	Гал түймрийн үед дүрвэн гарах схем байгаа эсэх		
9	Шалгалт хийсэн ажилтаны нэр		

"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн
А/136 тоот тушаалын хавсралт 2



**"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хэлтэс, нэгжүүдийн
зайлшгүй дагаж мөрдөх галын аюулгүй
байдлын дотоод дүрэм**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм болон энэхүү дүрмийг "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын хэлтэс, алба, нэгжүүд дагаж мөрдөнө.

1.2. Тус байгууллагын галын аюулгүй байдлыг байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн /ХАБЭА/ зөвлөлийн гишүүд шууд хариуцан ажиллаж дараах үүргийг гүйцэтгэнэ.

1.2.1. Байгууллагын ажилтан, албан хаагч, инженер техникийн ажилтан /ИТА/ нараар энэ дүрмийг судлуулан мөрдүүлнэ.

1.2.2. Байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүд Галын аюулаас урьдчилан сэргийлэх /ГАУС/ бүх ажлыг хэлтэс, албуудад зохион байгуулна.

1.2.3. Хэлтэс, албуудын эд хөрөнгө, материалын агуулах, өрөө тасалгаануудад ГАУС нарийн дэг тогтоож, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг MNS5566:2005 /Аж ахуйн нэгж, байгууллагуудад зайлшгүй байх шаардлагатай гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн норм/ стандартын дагуу хангаж, түүнд зориулагдсан хөрөнгийг байгууллага санхүүгийн төлөвлөгөөнд тусгана.

1.2.4. Хэлтсүүдийг гал түймрээс хамгаалагдсан байдлыг тогтмол хянаж, холбоо дохиолол, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бүрэн бүтэн байлгаж, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургана.

1.2.5. Агааржуулалт, халаалт, цахилгаан хэрэгсэл болон техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гал гарч болзошгүй гэмтэл зөрчлийг засуулах, ажил дууссаны дараа ажлын байраа цэвэрлэх, цахилгаан тоног төхөөрөмжийг хүчдэлээс салгах, гал гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж тогтмол шалгана.

1.3. Гарсан гал түймрийг үүрэг бүхий ажилчид нь галын аюулгүй байдлын стандарт норм дүрмийг нарийн чанд мөрдөж, бусдаас түүнийг биелүүлэхийг шаардах, гал түймэр гарсан үед бололцоотой дэмжлэг туслалцаа үзүүлэх.

1.4. Байгууллагын байрны эргэн тойронд машин явах, зогсох, эргэх бүрэн боломжтойгоор тохижуулсан, хашааны дотор талыг шөнийн цагт гэрэлтүүлгээр хангасан байна.

Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах үед
баримтлах галын аюулгүй байдлын шаардлага

- Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж байгаа байгууллага нь арга хэмжээ, үзвэр үйлчилгээг зохион байгуулахаас өмнө тухайн объектын галын аюулгүй байдлыг шалгаж, аюулгүй байдлыг бүрэн хангасан байна.

- Өрөө, танхимд үзэсгэлэн гаргах зорилгоор барилгын дотоод байршил, тоног төхөөрөмжид өөрчлөлт хийхдээ шат, аврах бусад гарц руу очих зам гарцыг хаах, нэвтрэх зайг багасгахыг хориглоно.

- Олон хүн нэг дор байрлах барилга байгууламж нь цахилгаан тасарсан тохиолдолд ослын гэрэлтүүлэг, дуут мэдээлэгчтэй байх бөгөөд объектын онцлог, багтаамж, барилгад байгаа хүмүүсийн тооноос хамааруулан тооцож гар чийдэн байрлуулна. Барилга байгууламжийн харуул хамгаалалтын бүрэлдэхүүн нь иж бүрэн гэрэлтүүлэх хэрэгслээр хангагдсан байна.

- Олон хүн байрлах барилгын шал болон шатанд дэвссэн хивс, хивсэнцэр нь сайтар бэхлэгдсэн байна.

- Аврах зам, гарцад байрлах “аврах гарц”, “аврах хаалга” зэрэг гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь тэжээлд байнга залгаж асаалттай байх бөгөөд үзвэрийн газарт танхимаас хүмүүс гарсны дараа унтрааж болно.

- Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон байна.

- Талбайн болон тайзны гэрэлтүүлгийг суурилуулан ашиглах тохиолдолд шатдаг материалд ойр байрлуулахыг хориглоно.

- Гэрэлтүүлэг, чийдэнг шатдаг материалаас 0.5 м, линзтэй гэрэлтүүлгийг 2 м-ээс багагүй зайтай байрлуулна. Тэдгээрийн гэрэл шүүгч нь шатдаггүй материалаар хийгдсэн байна.

- Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахдаа галын аюулгүйн шаардлагад нийцсэн 2-оос доошгүй аврах зам, гарцтай, цонх нь төмөр хаалтгүй байна. Давхар дундын хучилт нь шатдаг материалаар хийгдсэн тохиолдолд нэг, эсхүл хоёр давхарт байрлах танхимыг сонгоно.

- Нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулах үед байр, танхим болон тайзны үзлэгийг тогтмол хийж, арга хэмжээ дууссаны дараа барилга байгууламжид дахин үзлэг хийж жижүүрт хүлээлгэн өгнө.

- Шинэ жилийн арга хэмжээний үед сүлд модыг зам гарц, хаалганы дэргэд байрлуулахыг хориглох бөгөөд мөчрийг хана, таазнаас 1 м-ээс доошгүй зайтайгаар бат бэх суурилуулсан байна.

- Гэрэлтүүлэг, чимэглэл нь цахилгаан байгууламжийн дүрэм, журамд бүрэн нийцсэн байна.

- Галын аюулгүйн дүрэмд тусгайлан зөвшөөрөөгүйгээс бусад тохиолдолд аврах зам, гарцын дагуу байрлах хаалга нь барилгаас гарах чиглэлийн дагуу онгойхоор төлөвлөгдсөн байна.

- Аврах зам дахь хаалга нь дотор талаасаа түлхүүргүй чөлөөтэй онгойхоор байна. Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах үед дараах зүйлийг хориглоно.

- Гал түймэр гарах нөхцөл бүрдүүлэх, ил гал, галт сум, улайсагч гэрэлтүүлэг, дэнлүү, пиротехник зэргийг ашиглах;

- галын болон тэсрэх аюултай үйл ажиллагаа (гагнуур, будаг зэрэг) явуулах;

- өрөөний гэрэлтүүлгийг бууруулах зорилгоор цонхонд бууруулагч хальс, хаалт хийх;

- үзвэрийн танхимын суудал хоорондын зай хэмжээг багасгах, нэмж илүү суудал

тавих;

- арга хэмжээний үеэр танхимын гэрлийг бүрэн унтраах;

- тогтоосон хэмжээнээс илүү хүн танхимд оруулах.

- Гадаадын иргэн, аж ахуй нэгж, байгууллага хоёр улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу, эсхүл бие даан үзэсгэлэн, үзвэр, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа Монгол Улсад мөрдөж байгаа галын аюулгүй байдлын дүрмийн шаардлагыг дагаж мөрдөнө.

- Соёл урлаг, спорт, түүх дурсгал, шашны байгууллага, үзвэрийн газар нээлтийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж байгаа эсэхээ мэргэжлийн байгууллагаар шалгуулж илэрсэн зөрчлийг арилгасан байна.

Хоёр. Цахилгаан

2.1. Цахилгааны систем

2.1.1. Ашиглалтад байгаа цахилгаан системийн галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж, бүрэн бүтэн гэмтэлгүй байлгахыг ХАБЭА-н зөвлөл шууд хариуцна.

2.1.2. Цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан шугам сүлжээ, цахилгаан хэрэгслийн угсралт, ашиглалт, техникийн үйлчилгээ, хяналтыг тэдгээрийн дүрэм, журамд заасны дагуу мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэнэ.

2.1.3. Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглаж дууссаны дараа гал түймрээс хамгаалах болон ослын гэрэлтүүлгээс бусад төхөөрөмжийг хүчдэлээс бүрэн салгана. Бусад цахилгаан тоног төхөөрөмж, ахуйн цахилгаан хэрэгслийг тэдгээрийн ашиглалтын баримт бичигт заасан тохиолдолд хүчдэлээс салгахгүй орхиж болно.

2.1.4. Цахилгаан дамжуулах агаарын шугамыг шатдаг бараа материал, эд зүйл, задгай агуулахын дээгүүр татах, эсхүл шатдаг материалаар хийгдсэн дээвэр дээр дамнуулан татахыг хориглоно.

2.1.5. Аянгын хүчтэй үйлчлэлийн бүсэд байрласан барилга байгууламж нь барилгын норм, дүрмийн шаардлагыг хангасан аянгаас хамгаалах төхөөрөмжөөр тоноглогдсон байна.

2.1.6. Цахилгаан тоног төхөөрөмж, гэрэлтүүлэг, хөдөлгүүр, цахилгаан дамжуулах утсыг орчны нөхцөл, үйлдвэрийн галын болон тэсрэх аюулын зэрэгт тохируулан сонгон хэрэглэнэ.

2.1.7. Барилга байгууламжийн угсралт, засварын ажлаас бусад нөхцөлд цахилгаан шугамыг түр хугацаагаар тавьж ашиглахыг хориглоно.

2.1.8. Шатдаг материалаар хийсэн хайрцаг, сав, баглаа боодол бүхий бүтээгдэхүүн ашигладаг үйлдвэр, агуулахын барилгад шилэн бүрхүүл бүхий хамгаалалттай цахилгаан гэрэлтүүлэг хэрэглэнэ.

2.1.9. Ашиглаж байгаа цахилгаан шугаманд шинээр хэрэглэгч холбохдоо техник хяналтын тооцоог үндэслэн зөвхөн цахилгааны аюулгүй байдлыг хариуцсан байгууллагын шийдвэрээр гүйцэтгэнэ.

2.1.10. Барилгад цахилгаан дамжуулах утсыг ил татахдаа механик гэмтэл учирч болох хэсгүүдэд төмөр хоолой болон нэмэлт хамгаалалт хийнэ.

2.1.11. Цахилгааны шугам, утсыг инженерийн шугам сүлжээ, утааны яндан, халуун усны хоолойтой зэрэгцүүлэн ил, далд байдлаар татаж ашиглахыг хориглоно.

Цахилгаан тоног төхөөрөмжийг ашиглах үед дараах зүйлийг хориглоно.

2.1.12. Дамжуулагчийн тусгаарлагч нь шалбарч гэмтсэн, ашиглалтын явцад тусгаарлах чанараа алдсан шугам, дамжуулагч утсыг ашиглах;

2.1.13. Хүчдэлд тохироогүй чанарын шаардлага хангахгүй гал хамгаалагч хэрэглэх;

2.1.14. Цахилгаанаар халах хэрэгслийг шатдаг материалаар хийсэн суурьтай ашиглах, хяналтгүй орхих;

2.1.15. Барилга байгууламжийг халаах зорилгоор стандарт бус цахилгаан зуух, бусад төхөөрөмж ашиглах;

2.1.16. Цахилгаан гүйдэл бүхий кабель шугам, дамжуулах утасны хамгаалалтгүй үзүүрийг ил орхих;

2.1.17. Гэмтэлтэй цахилгаан хэрэгсэл ашиглах;

2.1.18. Цахилгаан дамжуулах утсыг хадаасаар бэхлэх, хаалганы хавтасны завсараар гаргах, цахилгааны утас, унтраалгаас эд зүйл өлгөх;

2.1.19. Гэрлийн чийдэнгийн шилийг цаас, өөр төрлийн шатдаг материалаар ороох;
2.1.20. Цахилгааны хянах самбар, цахилгаан хөдөлгүүр, асааж унтраах аппаратын дэргэд шатамхай (хялбар авалцан асах) бодис, материал байрлуулах, хураах.
2.1.21. Агаар сэлгэлтийн хоолой дахь гал баригч (хаалт, хавхлага зэрэг), галын автомат дохиоллын систем, гал унтраах болон гал түймрийн үед автоматаар агаар сэлгэлтийг салгадаг төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлгана.

2.2. Халаалтын систем

2.2.1. Халаалтын системийн тоног төхөөрөмжийн ашиглалтын техникийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлыг ХАБЭА-н зөвлөлийн гишүүд шууд хариуцна.

2.2.2. Халаалтын улирал эхлэхээс өмнө уурын тогоо, бусад халаалтын хэрэгслийг заавал шалгана. Гэмтэлтэй болон бүрэн бус халаалтын төхөөрөмжүүд ашиглахыг хориглоно.

2.2.3. Халаалтын системийг хариуцсан ажилтан халаалтын ажиллагаа эхлэхээс өмнө галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаа авсан байна.

2.2.4. Халаалтын системийн өрөөнд дараах зүйлийг хориглоно.

- Тогоо ба уур дамжуулах хоолой дээр шатах материал хатаах,
- Уурын тогооны үйлчилгээтэй холбоотой ажил явуулах,
- Халаалтын системийг хариуцсан байгууллагаар уурын тогоог хянуулах,
- Халаах хэрэгсэл, дулаан дамжуулах хоолойд ажлын хувцас, тостой даавуу ба шатамхай материал тавих,
- Автомат бус ажиллагаатай уурын тогоог хариуцах эзэнгүй орхих,

2.3. Агааржуулалтын систем

2.3.1. Ашиглалтад байгаа агааржуулалтын системийн галын аюулгүй байдлын шаардлагыг хангаж, бүрэн бүтэн гэмтэлгүй байлгахыг ХАБЭА-н мэргэжилтэн, хэлтсийн дарга нар шууд хариуцна.

2.3.2. Зааварт агааржуулалтын системийн фильтр, оч баригч агаар дамжуулагч хоолой бусад тоног төхөөрөмжийн цэвэрлэх хугацаа зэрэг галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд болон гал түймэр гарсан үед сантехникийн ажилтнуудын гүйцэтгэх үүргийг тусгасан байна.

2.3.3. Агааржуулалтын системийн бүрэн бүтэн байдлыг 7 хоногт нэг удаа шалгана.

2.3.4. Ээлжийн болон ИТА нар сэнс, агаар дамжуулах хоолой, оч баригч, газардуулгын хэрэгсэл зэрэг тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх үзлэгийг төлөвлөгөөтэй хийж, гал түймэр гаргах ба гарсан гал түймэр цааш дэлгэрүүлж болзошгүй гэмтлүүдийг цаг тухай бүрд нь засах арга хэмжээг авна.

Гурав. Үндсэн ба туслах чанарын барилга, байгууламж, агуулахад тавих галын аюулгүйн шаардлага

3.1. Лабораторит баримтлах болон хориглох заалт

3.1.1. Лабораторит ажиллаж байгаа хүн бүр өөрийн хэрэглэж байгаа химийн бодис, урвалж галын аюулгүй байдлын шинж чанарыг сайн мэддэг, галын аюулгүйн дүрмийг судалсан байх ба чанд сахин ажиллана. Лабораторит бодис материал хадгалахдаа түүний хадгалах дүрмийг хатуу баримтална.

3.1.2. Лабораторид тоног төхөөрөмж, тавилгыг аврах зам, гарцад саад болохгүйгээр хооронд нь 1 м-ээс багагүй зайтай байрлуулна.

3.1.3. Гал түймрийн ба тэсэрч дэлбэрэх аюултай шингэн бодис, материалд зориулагдсан ширээ, татах шүүгээний дээд тал нь шатахгүй материалаар хийгдсэн байна.

3.1.4. Лабораторийн агааржуулалтын системийг ажил эхлэхээс 5 минутын өмнө ажиллуулна.

3.1.5. Хийтэй баллоныг дулаан үүсгэгч буюу халаах хэрэгслээс 1 метр, ил галаас 5 метрээс доошгүй зайд байрлуулна.

3.1.6. Хийн тоног төхөөрөмжийг ажиллуулж байх үед хараа хяналтгүй орхихгүй байх,

3.1.7. Агааржуулагч ажиллуулах эсвэл өрөөний салхивчийг нээлттэй байлгах,

Баллон солих үед ил гал гаргахгүй байх, цахилгаан тоног төхөөрөмжийг салгасан байх,

3.2. Төлбөр авах цэгийн байруудын баримтлах болон хориглох заалт

3.2.1. Төлбөр авах цэгт ажиллаж байгаа хүн бүр өөрийн хэрэглэж байгаа химийн бодис, урвалж галын аюулгүй байдлын шинж чанарыг сайн мэддэг, галын аюулгүйн дүрмийг судалсан байх ба чанд сахин ажиллана. Төлбөр авах цэгт бодис материал хадгалахдаа түүний хадгалах дүрмийг хатуу баримтална.

3.2.2. Төлбөр авах цэгийн байранд байгаа тоног төхөөрөмж, тавилгыг аврах зам, гарцад саад болохгүйгээр хооронд нь 1 м-ээс багагүй зайтай байрлуулна.

3.2.3. ТАЦ-ын байрны агааржуулалтын хоолойг байнга ажиллуулна.

3.2.4. Халаагч тенийн залгуурын утсыг өдөр бүр шалгаж, хананаас 0.5м-т байрлуулна.

3.2.5. Цахилгаан тогоо болон ус буцалгагчийг ажиллуулахын өмнө цахилгааны утасны бүрэн бүтэн байдлыг шалгах, хоол, цай хийсний дараа хүчдэлийг салгасан байх,

3.2.6. Ил гал гаргахгүй байх

3.2.7. Агааржуулагч ажиллуулах эсвэл өрөөний салхивчийг нээлттэй байлгах

3.3. Техник ашиглалтын түвшин тогтоох /ТАТТ/ ажлын үед баримтлах болон хориглох заалт

3.3.1. ТАТТ ажлын үед ажиллаж байгаа хүн бүр өөрийн хэрэглэж байгаа химийн бодис, урвалж галын аюулгүй байдлын шинж чанарыг сайн мэддэг, галын аюулгүйн дүрмийг судалсан байх ба чанд сахин ажиллана. Хээрийн нөхцөлд ажиллаж байгаа үед машиндаа техник, тоног төхөөрөмж болон химийн бодис, материал хадгалахдаа түүний хадгалах дүрмийг хатуу баримтална.

3.3.2. Тоног төхөөрөмж болон зөөврийн моторын залгуурын утсыг өдөр бүр шалгаж, ажиллуулна.

3.3.3. Ил гал гаргахгүй байх,

3.3.4. Тусгай бодис, шатахуунаар ажилладаг төхөөрөмжний таглаа, бөглөөгүй ажиллуулах, машинд байршуулах

3.4. Авто зогсоолд баримтлах болон хориглох заалт

3.4.1. Авто машиныг битүү болон ил зүгсоолд байрлуулахдаа авто зогсоолын стандартын дагуу хоорондын зайг баримтална.

3.4.2. Авто машины хөдөлгүүрийг ил галаар гэсгээх,

Гагнуур, будаг, мужааны ажил, хялбар авалцан асах шингэнээр эд зүйл, тоног төхөөрөмж угаах,

3.4.3. Авто машины түлшний нөөцийн сав цоорхой, таггүй байх,

3.4.4. Шатахууныг зориулалтын бус саванд хадгалах,

3.4.5. Авто машины асаах түлхүүрийг түлхэж орхих, аккумуляторын ерөнхий залгуурыг салгахгүй орхих,

3.4.6. Авто машины засвар, үйлчилгээ хийх,

3.5. Бараа материалын агуулах

3.5.1. Агуулахад бараа материалыг хадгалахдаа агуулахын стандартыг баримтална.

3.5.2. Агуулахыг пийшин зуух болон цахилгаан халаагнаар халаах мөн ил разетка хэрэглэхийг хориглоно.

3.5.3. Бараа материалыг тусгай тавиур дээр хурааж, авралтын зам гарц, бараа материал зөөх зориулагдсан зай үлдээнэ.

3.5.4. Агуулахын цахилгаан залгуур нь барилгын гадна хананд шатахгүй суурь дээр бэхлэгдсэн байх ба зориулалтын ус чийг, тэсрэлтээс хамгаалагдсан разетка байна.

3.5.5. Нярав нь ажил дууссаны дараа агуулахаа шалгаж цахилгаан тоног төхөөрөмжөө салган гапын аюулгүй байдлыг хангана.

Дөрөв. Засвар үйлчилгээ, угсралтын ажлын үеийн
галын аюулгүй байдлын шаардлага

4.1. Объектод байрлуулсан гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл тоног төхөөрөмжид засвар, үзлэг үйлчилгээ хийх үед тухайн ажлыг удирдаж байгаа албан тушаалтан гүйцэтгэнэ.

4.2. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, аваагүй үед ажлын байранд ил гал ашиглан үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.3. Байгууллагын удирдлага, ХАБЭА-н зөвлөлийн гишүүд ил гал ашигласан ба бусад галын аюултай ажил явуулсан байранд 3-5 цагийн турш эргүүл шалгалт хийнэ.

Тав. Гал унтраах усан хангамж, галын
техник ба холбооны хэрэгсэл

5.1. Гал түймэр унтраах усны эх үүсвэрийн сүлжээ нь тооцооны дагуу шаардагдах усыг өгөх даралттай байна. Усны даралт хүрэлцэхгүй үед даралт өсгөгч мотор тавина. Гал унтраах усны хангамжийн шугам сүлжээний даралтыг бууруулах үед гал түймрийн улсын хяналтын байцаагчид урьдчилан мэдэгдсэн байна.

5.2. Байгууллагын нутаг дэвсгэрт байгаа усан сан, нуур цөөрөмд очих зам гарц ямагт чөлөөтэй байна.

5.3. Гал түймэр унтраах техник тоног төхөөрөмж, холбооны хэрэгслийг бүрэн бүтэн байлгаж, засвар үйлчилгээг цагхугацаанд нь хийлгэхийг байгууллагын удирдлага хариуцна. Ажлын байранд байгаа гал унтраагуур, багаж хэрэгслийг холбогдох албан тушаалтанд хариуцуулж өгсөн байна.

5.4. Ажлын байранд байгаа гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг зориулалтаас өөр зүйл ашиглахыг хатуу хориглоно. Гэнэтийн аюул ослын үед байгууллагын даргын зөвшөөрлөөр ашиглана.

5.5. Гал унтраагуур, анхан шатны багаж хэрэгслийг байгууллагын барилга, агуулахын гадна тусгай газар байрлуулсан байна.

5.6. Гал унтраагуурыг нарны шууд тусгалаас хол, хананд шалнаас 1.3-1.5м өндөрт, хүний нүдэнд харагдахуйц байрлалд байрлуулна.

5.7. Галын дотор усан хангамжийн даралтат цэгийг байвал зохих хошуу хоолойгоор тоноглож, шкафын шилэн дээр ГК гэсэн үсэг, 101, 105 тоот дугаарын хамт тэмдэглэсэн байна.

5.8. Гал түймэр гарсан үед дохиолол өгөх, дохиоллын системтэй байна.

5.9. Гал гамшгийн үед зарлан мэдээлэх дуут дохиотой байна.

Зургаа. Гал түймэртэй тэмцэх байгууллага,
байгууллагын захиргааны хамтын ажиллагаа

Гал түймэр гарсан объектын захиргаа нь гал түймрээс хүмүүс, эд хөрөнгийг аврах аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

6.1. Гал түймрийг анх илрүүлсэн ажилтан, албан хаагчийн үүрэг

6.2 Гал түймрийг унтраах, аврах ангийг яаралтай дуудна.

6.3 Боломжтой бол гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуур, барилгын дотор усны цэг, гал унтраах тоног төхөөрөмж ашиглан гал унтраах арга хэмжээг авна.

6.4 Гал гарсан газар ээлж, хэлтсийн дарга бусад хариуцлагатан, албан тушаалтанд

мэдэгдэнэ.

- 6.5 Гал гарсан газар ирсэн хэлтсийн дарга бусад албан тушаалтны үүрэг.
- 6.6 Гал түймэр унтраах, аврах анги дуудсан эсэхийг шалгах,
- 6.7 Байгууллагын удирдлагад мэдэгдэх,
- 6.8 Гал түймэр унтраах, аврах анги иртэл гал унтраах ажлыг удирдах,
- 6.9 Зам талбай, усан санг сайн мэдэх хүнээр гал түймэр унтраах, аврах анги ирэхэд угтуулан замчлуулах,
- 6.10 Гал унтраах автомат тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах,
- 6.11 Гал унтраах ажилд оролцоогүй ажилтан, албан хаагчдыг галын голомт, аюултай бүсээс гаргах,
- 6.12 Хүний амь насанд аюул учирвал өөртөө байгаа хүч хэрэгслийг ашиглаж, аврах ажиллагааг яаралтай зохион байгуулах,
- 6.13 Шаардлагатай нөхцөлд эмнэлэгийн түргэн тусламж, цахилгааны аваарын жижүүр болон бусад шаардлагатай албуудыг дуудах,
- 6.14 Гал түймэр унтраах үед бусад бүх ажлыг зогсоох,
- 6.15 Шаардлагатай бол бүх инженерийн шугамын ажиллагааг зогсоох, гал түймэр унтрааж байгаа хүмүүсийг цахилгаан гүйдэлд цохиулах, шатаж, гэмтэхээс хамгаалах арга хэмжээ авах,
- 6.16 Гал унтраах үүргийг удирдаж байгаа объектын удирдлага нь гал унтраахаар ирсэн гал унтраах удирдагчид объектын мэдээлэл, цацраг идэвхт болон хорт бодисууд байгаа эсэх байгууллагын технологийн онцлог зэргийг тодорхой мэдээлэх.

Долоо. Байгууллагад байвал зохих гал унтраах
анхан шатны багаж хэрэгслийн жагсаалт

7.1. Байгууллагын агуулах, туслах ба захиргааны барилга, байгууламжууд технологийн тоног төхөөрөмжүүд нь MNS 5566:2005 стандартын дагуу MNS 6413:2013 стандартын шаардлага хангасан гал унтраагуур болон гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр тоноглогдсон байна. Байгууллагын гал унтраах хэрэгсэлд:

- Хумбан хүрз иштэй
- Багор дэгээ /2м урттай, Галаас хүн, эд зүйл татаж гаргах зориулалттай/
- Галын сарай /1.5мх2мх1.8м/
- Шулуун лоом, царил /Түгжээтэй хаалга, цонх онгойлгох зориулалттай/
- Галын гурвалжин хувин /8 литр, өөр зориулалтаар ашиглуулахгүй зорилгоор гурвалжин суурьтай байдаг. Гал гарсан үед зөвхөн ус, элс цацах зориулалттай./
- Жоотуу
- Галын хор /MNS5566-2005 нунтаг, хий, хөөс, ус/
- Гэрэл асдаг гарцын тэмдэгт, EXIT /ногоон өнгөтэй, 90 минут асах цэнэг хураана, тогонд залгана/
- Гарцын фосфортой тэмдэг, EXIT /14смх36см хэмжээтэй, ногоон өнгөтэй, гэрлээр цэнэг авч, харанхуйд фосфортлоно, ар талыг хуулаад шууд наана/.
- Галын аюулгүй байдлын тэмдгүүд

...оОо...